# Аймгийн адуучдын анхдугаар

## Хусан уургаа барьсан хурдан хүлгийн эзэд

*(СУРВАЛЖИЛСАН ТЭМДЭГЛЭЛ)*

Тосон Заамар, Уулын хаан, Баян суудал, Бадын гол, Долоон давст, Баянтөхөм, Хоёр Өнжүүл хүртлэх 1000 гаруй км үргэлжилсэн өргөн уудам нутгаар бид явсан юм.

Бидний явсан газраар урт сайхан намар болж малчин түмний сэтгэл тэнүүн, идээ цагаагаа хувин саваар дүүргэж, аж амьдрал нь элбэг баян, ажил үйлс нь өөдрөг сайн, түм буман сүрэг малын хүч тарга зузаан байгааг үзэхэд хэн бүхний сэтгэл таатай.

Энэ нутгийнхан ноос, үс, сүү сааль, хадлан тэжээлээ авч, тариа ногоогоо хурааж дуусаад өвөлд өнөтэй, хаварт тавтай орохын бэлтгэл их ажлыг цагийн сайхан тэнгэрийн аятайд хийж дуусгахаар, хураасан өвс, малын хашаа, хээрийн б и лчээр, худаг ус, өвөлжөө, хаваржаан дээрээ хамт олноороо шамдан ажиллаж байгаа нь намар цагийн дуулиантай их ажил намар намраас улам эрчимтэй сайн явагдаж байгааг гэрчилж байв

Тэр бүгдийн дундаас хатуу өвөл, хахир хавар, үүрийн жавар, үнэгэн харанхуй, өлөн чоно, усан бороо, цасан шуургатай олон удаа тааралдаж, тохиолдсон бэрхшээлийг түмнээ гэх сэтгэл, чин үнэнч хөдөлмөрөөрөө даван туулсан удаан жилийн зузаан туршлагатай зарим адуучдын амжилт бүтээлтэй танилцахад нэн сайхан санагдана.

### АНАНД ГУАЙ ЗӨВЛӨЖ БАЙНА

Билчээрээс ирж яваа эхээ хараад зэл дүүрэн унага эргэлдэн янцгааж, гүү сааж байгаа хүмүүсийн Гурий! богос! гэсэн бүдүүн нарийн дуу цууриална.

Алаг хушууны өвөрт намаржиж байгаа х о т айлынхан оройн ажлаа дуусгах гэж хүн бүр зав чөлөөгүй ажиллаж байгаа нь энэ билээ.

Хот айлын гадна очиход намрын айрагны исгэлэн үнэр хамар цоргин сэнгэнэж, манаанд гарах адуучин эр, цув давхцаа аваад мориндоо мордож байв.

3 хувин сүү бариад иржяваа 2 хүнийг тосон уулзаж мэндлэхэд 60 гаруй настай гэхэд анууухан, нар салхинд борлосон хүрэл хүрэн царайтай нилээд сэргэлэн байрын өндөр х ү н суурийн ахлагч Ананд гэж өөрийгөө танилцуулав.

Гэрийн эзэгтэй хул дүүрэн айргаар биднийг зочлох зуур Ананд гуайн аж байдал ажил бүтээлтэй нь танилцаж нилээд зүйлийг мэдэж авсан юм.

Би нэгдэл анх байгуулагдаж хамт олноороо хүч хөрөнгөө нэгтгэсэн тэр өдрөөс эхлэн чадлынхаа хирээр ажил хийж, хийснийхээ хэмжээгээр хөлс аваад аж амьдрал дээшилж, хүний жишээтэй бүтээл гаргаж явна.

Болж л өгвөл хийсэн ажилдаа алдаа гаргахгүй, хамт олны сан хөрөнгийг арвижуулж үр бүтээлтэй ажиллах юмсан гэж бодгогдоо гэж Ананд гуай ярьж байна.

Ананд гуай сүүлийн 6 жил дараалан нэгдлийн 100—120 гүү маллаж, фермийн аргаар саалгаж нэгч адууны хорогдолгүй, сүү саалийн төлөвлөгөөг давуулан биелүүлж нэгдэлдээ олон зуун төгрөгийн ашиг оруулжээ.

Зөвхөн саалийн хугацаанд 100 гаруй гүү маллах нь Ананд гуайд бас л бага ажил шиг санагдаж энэ оны эхээр 300 гаруй адуу байнга маллахаар аваад энэ хавар 112 гүүнээс 112 унага бойжуулж одоо 400 гаруй адуутай болоод байна.

Эднийх хөөвөр хялгасны төлөвлөгөөг давуулан биелүүлж зүй бусын хорогдол гаргаагүй энэ жил саалийн 30 хоногт 120 гүү хариуцан саалгаж, гүү бүрээс 270 литр сүү авч, үйлдвэрийн даалгаврыг биелүүлсэн байна.

Ананд гуайн гэргий Хорол гуай ч бас сайн саальчин хүн. Хорол гуай сүүлийн 6 жилд 25—30 гүү хариуцан г ү ү бүрээс 250—280 литр сүү саажээ.

Энэ жил 30 гүү хариуцан одоогийн байдлаар гүү бүрээс 300 литр сүү саагаад байгаа аж.

—Адуу маллаж, унага бойжуулдаг туршлагаасаа ярьж өгнө үү? гэхэд нададтуршлага гэж хэлээд байх юм байхгүй, адууны нутгийг улирлын байдалд тохируулж, ус хужир, өвс билчээрийг сонгож маллавал адуу шиг амархан таргалдаг мал байхгүй.

Харин нутаг алдвал, өнгө зүсээ алдаж шарлаж гандаад тэвээрч чаддаггүй юм. Тийм учраас зун намрын улиралд өвс ногооны сэрмүүн сайхныг дагуулж цэнгэг хүйтэн усаар өдөрт 2 удаа, өглөө, орой услаж 7 хоногт нэг хужирлаад байвал сайн таргална.

Ер нь адуу сайн маллана гэдэг шөнийн манааг тогтмол хийнэ гэсэн үг. Манаатай адуу бүрэн мэнд байхаас гадна адуу тогтвор орж идээшлэх хугацаа хүртэл урт болдог.

Адуу манахгүйгээр уна-



*Өндөршилрээт сумын „Хөгжил" нэгдлийн адуучин Шагдаржав сүүлийн 6 жил дараалан 700-900 адуу маллаж, унага бойжуулах төлөвлөгөөг давуулан биелүүлдэг юм.*

**Д. Дондогдоржийн авсан гэрэл зураг**

## Номын сан уншлагын газар хөдөлмөрчдийн чухал хэрэгцээ

МАХН-аас манай орны хөдөлмөрчдийн о ю у н ухааны дээж, эрдэм мэдлэг арвин туршлагын ундраа болсон номын сан, уншлагын газрын орон байрыг тохижуулах, шинээр барих, номын сангийн номын фонд, уншигчдын хүрээг байнга нэмэгдүүлэх, ном хэвлэлийн ангилалт, каталог, нэг бүрчилсэн бүртгэлийг журамлан хөтлөх зэрэг ажлыг хийсний үндсэнд номын сан уншлагын газрыг хөдөлмөрчдийн соёлын жинхэнэ төв болгон олон түмэнд тодорхой үйлчлүүлэх талаар цаг ямагт анхаарал тавьсаар ирлээ.

МАХН-ын 15 дугаар их хурлын түүхэн шийдвэрийг амьдралын алхам бүхэнд ажил хэрэг болгоход номын сан, уншлагын газар чухал үүрэгтэй.

Одоо тус аймгийн сумнэгдэл, САА, үйлдвэр албан байгууллага, бага дунд сургуулиудад 130 мянга гаруй боть номын фондтой, 27 номын сан, 49 уншлагын газар ажиллаж байна. Нэгдэл, САА-н бригад, фермүүдэд уншлагын газартай болох эхлэл тавигдлаа. Энэ бол манай нам, засгаас хөдөлмөрчдийн соёл боловсролын хэмжээг улам дээшлүүлэхийн төлөө цаг ямагт анхаарал халамж тавьж байдгийн нэг тод баталгаа мөн. Олон түмэнд марксизм—ленинизмын үндсийг сурталчлах, шинжлэх ухааны мэдлэг олгох, нам засгийн тогтоол шийдвэрийг таниулж, түүнийг биелүүлэхэд олон түмний хүчийг дайчлан идэвхийг нь өрнүүлэх явдал номын сан, уншлагын газрын үүрэг мөн.

Алтанбулаг сумын номын санч Долгор, Өнжүүл сумын номын санч Чимэдпэл, аймгийн төвийн хүүхдийн номын санч Хишгээ, Жаргалант сумын номын санч Дуламсүрэн нарын зэрэг олонхи сумдын номын санчид малчдын дунд ном түгээн уншуулах, ном хэвлэл сурталчлах талаар туршлагажиж уншигч олны хэрэгцээг сайн ханган үйлчилж байна.

Аймгийн төвийн номын сан Д. Нацагдоржийн нэрэмжит оргил булаалдах уралдаант уншлага хөдөлмөрчдийн дунд сүүлийн жилүүдэд зохион явуулж байгаа ба хүүхдийн зурагт каталог хийж номын санд нэвтрүүлснээр бага насны хүүхдийн ном унших идэвхжилийг өрнүүлж унших номоо олж уншихад хялбар дөхөм болгожээ.

Аймгийн номын сан сүүлийн 5 жил дараалан номын фондоо өсгөх зорилт тавьж сэхээтэн нийт уншигчдын дунд ном цуглуулах уралдаан зарлах зэрэг нилээд ажил санаачлаж хийсний дүнд ЗХУ-ын болон өөрийн орны ховор чухал олон мянган ном цуглуулж чаджээ.

Мөн өөртөө байхгүй номыг улсын номын сантай түр солилцоо хийж уншигчдад үйлчлэх зэрэг үйлчилгээний давшилттай а р г а хэлбэрүүд тус аймгийн нилээд сум—нэгдэл, САА-н номын санд нэвтэрч эхлэж байна.

Гэвч төв орон нутгийн зарим номын сан уншлагын газар хөдөлмөрчдөд ном уншуулах талаар олигтой ажил зохиохгүй, уншигчдын хүссэн номыг бригад, суурь, цех, тасаг, гэр байранд нь хүргэж олгохгүй, зөвхөн уншлагын танхимд хэзээ хүн ирж ном авахыг хүлээх, ном хэвлэлийг сурталчлан хөдөлмөрчин олонд хүргэх талаар санаачлан олон нийтийн байгууллагатай хамтран тодорхой ажил зохиохгүй байгаад номын сангийн үндсэн дутагдал оршиж байна.

Заамар, Бүрэн, Баянзүрх, Баяндэлгэр, Эрдэнэсант, Сэргэлэн зэрэг нэгдлийн номын сангийн номын тоо нэр төрөл цөөн, байнгын уншигчид маш бага байгаа нь дээрх сумдын нам, захиргааны байгууллага номын санг тохижуулах, номын фондыг арвижуулахад бага анхаарч байна.

Заамар, Баяндэлгэр сумандЗХУ-ын тусламжаар клуб дотроо зориулалттай бүрэн тоног төхөөрөмж бүхий номын сан барьж ашиглалтанд оруулсаар байтал номын сангийн номын фонд идэвхитэн уншигчдын хүрээг өргөтгөх талаар олигтой ажил зохиосонгүй.

Баянбараат, Лүн зэрэг зарим сумд номын санчийг сүүлийн хоёр жилд 2—4 удаа сольж түүний оронд ямарч мэргэжилгүй хүн ажиллуулсанаас болж, номын сангийн зарим ажилтан ном зүйн мэдлэгээр дутмаг номын сан дахь